

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVIII (610)

DOI: 10.22353/ms20244817

УРТ ЭГШИГИЙН ҮҮСЭЛ, ХУВЬСАЛЫН ТУХАЙ АСУУДАЛД¹

Д.Төмөртоогоо

Хураангуй: Монгол хэлэнд урт эгшиг үүсэн бүрэлдсэн явдал нь авианы түүхэн хөгжилд гарсан томоохон хувьсал юм. Монгол хэлний урт эгшигийн гарал, хувьсалын талаар бараг 200 шахам жил тасаралтгүй судлагдсаар иржээ. Гэвч урт эгшиг үүссэн цаг хугацаа, түүний авианы орчин, гадаад нөлөөлөл, бичигт түүнийг хэрхэн тэмдэглэсэн тухай хийгээд нэгэнт үүссэн урт эгшиг эргэн тойрондоо ямар нөлөө үзүүлсэн тухай асуудал маргаантай хэвээрээ байсаар байна. Бид энэ үгүүлэлдээ дээр дурдсан асуудалуудын талаархи судалгааны тоймыг хураангуйлан дурдаад, тус бүрд нь өөрийн саналаа илэрхийлсэн болно.

Түлхүүр үг: Урт эгшиг үүссэн учир шалтгаан. Авианы хувьсалд үүсмэл урт эгшигийн нөлөө. Монгол бичиг, дөрвөлжин бичигт урт эгшигийг хэрхэн тэмдэглэсэн бэ?

Монгол хэлний авианы түүхэн хөгжилийн түүхэнд гарсан томоохон хувьсалын нэг нь урт эгшиг үүсэн бүрэлдэн явдал юм. Урт эгшигийн тухай асуудал нь бүр XIX зууны дунд үеэс эдүгээ хүртэл бараг тасаралтгүй судлагдсаар ирсэн боловч бас зарим асуудал эдүгээ хүртэл маргаантай хэвээрээ байсаар байна.

Ер монгол хэлэнд урт эгшиг үүсэн бүрэлдсэн хийгээд түүнтэй холбогдсон авианы хувьсалын тухай сэдэв нь доор дурдсан хэдэн асуудал дээр төвлөрч байна. Үүнд:

1. Монгол хэлний хөгжилийн аль үе шатанд урт эгшиг үүссэн бэ?
2. Авианы ямар байрлалд урт эгшиг үүссэн бэ?
3. Авианы ямар хувьсалын үр дүнд урт эгшиг үүссэн бэ?
4. Үүсмэл урт эгшиг авианы бүтэц, тогтолцоонд хэрхэн нөлөөлсөн бэ?
5. Урт эгшигийг бичигт хэрхэн тэмдэглэж байсан бэ?

Бид энд урт эгшигийн гарал, хувьсалтай холбогдсон дээрхи асуудалуудын талаар тус тусд нь авч үзэе.

1. Монгол хэлний хөгжилийн аль үед урт эгшиг үүссэн бэ? Монгол хэлний урт эгшиг үүсэн бүрэлдсэн цаг хугацааг эрдэмтэд өөр өөрөөр баримжаалан таамагласан байна. Тухайлбал: Sh. Hattori өвөг монгол хэлний Vγ/gV гэсэн нийлцийн дундах сул шүргэх [в]-гийн арын эгшиг нь уулаасаа урт байсан² гэж

¹ Энэхүү өгүүллийн бичвэрийг “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь” бичгийн дүрмийг дагалгүй Академич Д.Төмөртоогоогийн өөрийнх нь баримталдаг зарчмыг тэр хэвээр хадгалж хэвлэв.

² Sh. Hattori, The Length of Vowels in Proto Mongolian, ‘Mongolian Studies’ edited by L Ligeti, Budapest, 1970, 183

үзсэн бол М. Nomura өвөг монгол хэлэнд фонемийн үүрэгтэй урт эгшиг байсан³ гэж дурджээ. Дээрхи хоёр эрдэмтэн монгол хэлний урт эгшигийг үүсмэл бус, бүр өвөг монгол хэлний үед байсан анхдагч шинжтэй эгшиг гэж үзсэн байна. Түүнчилэн Н. Poppe хоёр эгшигийн хоорондох γ/g гийгүүлэгчийг суларан сугарахаас өмөнө түүний арын эгшиг нь урт байсан⁴ гэж дурдсан нь угтаа эртний монгол хэлний үед урт эгшиг байсан гэж үзсэн хэрэг юм. Харин Б. Я. Владимирцов “*Чингис хааны үеийн Монгол улас үүсэн бүрэлдэхээс бүр өмөнө урт эгшиг үүссэн*”⁵ хэмээн дурдсан бол хожим Ш. Лувсанвандан “*эртний монгол хэлнээс дундад үеийн монгол хэлэнд шилжиж байсан үеийн заагт буюу аравдугаар зууны эцэст урт эгшиг үүссэн*”⁶ гэж нилээд тодорхой тэмдэглэсэн байна. Харин А. Бобровников урт эгшиг үүссэн цаг хугацааны талаар тодорхой дурдаагүй боловч урт эгшигийн гаралыг төвөнхийн гийгүүлэгчтэй холбон тайлбарласанаас⁷ үзвэл дундад үеийн монгол хэлний үед хоёр эгшигийн дундах шүргэх гийгүүлэгч суларч төвөнхийн шинжтэй болсон түүнтэй холбож үзсэн бололтой. Бобровниковын үед монгол хэлний хөгжилийн түүхийг үечилж байгаагүй учир тодорхой үе шат зааж хэлэх боломжгүй байсан нь мэдээж.

Эртний болон дундад үеийн монгол хэлний бичигийн дураасхалууд хийгээд орчин үеийн олон монгол хэл аялгуунуудын материалыг монгол хэлний авианы хувьсан хөгжих ерөнхий зүй тогтолтой харьцуулан үзвэл урт эгшиг нь эртний монгол хэлний сүүлч үеэс үүсэн бүрэлдсэн байх бүрэн боломжтой.

2. Авианы ямар байрлалд урт эгшиг үүссэн бэ? Монгол хэлний урт эгшиг нь чухам авианы ямар орчинд үүссэн тухайд эрдэмтэдийн санал бас л бүрэн нэгдэлтэй болоогүй байна. Тухайлбал, Sh. Hattori $V\gamma V$, VgV гэсэн нийлцийн дундах сул шүргэх [к]-гийн арын эгшиг нь уулаасаа урт байсан⁸ гэж үзсэн бол Н. Poppe “*Дундад үеийн монгол хэлний үед γ/g гийгүүлэгч алгуурханаар гээгдэж, түүний хоёр талд байсан эгшигүүд нийлж нэг урт эгшиг болсон*” гэжээ.⁹ Ш. Лувсанвандан нар $V + \gamma/g + V$ гэсэн нийлцийн дундах γ/g -гийн арын өргөлтөт эгшигээс урт байсан гэж үзжээ.¹⁰ Тэдгээрээс гадна үүсмэл урт эгшигийн авианы орчины талаар К. Thomsen, Н. К. Верба, Н. Kuribayashi нар¹¹ тус тусдаа үгүүлэл нийтлүүлсэн бий.

³ М. Nomura, Long Vowels in Monguor Dialect and the Reconstruction of Long Vowel Phonemes in Proto-Mongolian, *Memoirs of the Faculty of Letters, Nagoya University*, 37, 1965, 1-40

⁴ N. Poppe, On the Velar Stops in Intervocalic Position in Mongolian, *UJb* 31, 1959, 271

⁵ Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, Лгр., 1929, 193

⁶ Ш. Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний урт эгшигийн гарлын тухай асуудалд, *ХЗС* 4:1, 1966, 22

⁷ А. А. Бобровников, Грамматика монгольско-калмыцкого языка, Казань, 1849, 14

⁸ Sh. Hattori, The Length of Vowels in Proto Mongolian, *‘Mongolian Studies’* edited by L Ligeti, Budapest, 1970, 183

⁹ N. Poppe, Introduction to Mongolian Comparative Studies (= MSFOu 110), 1955, 60

¹⁰ Ш. Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний урт эгшигийн гарлын тухай асуудалд, *ХЗС* 4:1, 1966, 22

¹¹ К. Thomsen, Entwicklung der Gruppe **uḡa* (**üge*) im Mongolischen, *АОН* 23, 1958, 263-267; Н. К. Верба, Монгольские письменные сочетания $V + j + i$ и репрезентация в современных монгольских языках, “*Вопросы грамматической системы монгольских языков*”, Элиста, 1980, 40-52; Н. Kuribayashi, The Development of **uḡa* and **üge* in Mongolian, *GK*. 85 (1985), 22-48

Дээрхи саналуудаас үзвэл монгол хэлний урт эгшигийн гаралыг судалсан олонхи эрдэмтэд CVC (Vγ/gV) гэсэн нийлцийн дотор урт эгшиг үүссэн гэж үзсэн байна. Миний бодоход, урт үүсэх явцад түүний өмөнөх шүргэх γ/g гийгүүлэгч болон бас түүний өмөнөх богино эгшигийн аль аль нь огт нөлөөлөөгүй учир CVC гэсэн нийлцээс урт эгшиг үүссэн гэж үзэх үндэслэл байхгүй. Харин тэрхүү бүтэц нь урт эгшиг үүсэн бүрэлдсэн авианы орчин болно. Бүр тодоруулбал, *‘өмөнөө богино эгшигтэй шүргэх γ/g-гийн арын байранд урт эгшиг үүссэн’* гэж томъёолох нь илүү оновчтой мэт.

3. Авианы ямар хувьсалын үр дүнд урт эгшиг үүссэн үүссэн бэ? Монгол хэлний урт эгшиг авианы ямар хувьсал, ямар нөлөөлөлийн үр дүнд үүссэн тухайд эрдэмтэд харилцан адигүй өөр өөр санал гаргажээ. Монгол хэлний урт эгшигийн гаралын тухай асуудалыг хамагийн анх хөндсөн А. Бобровников *“хоёр богино эгшигийн нийлцээс урт эгшиг үүссэн гэж төсөөлөх албагүй”*¹² гэж онцлон тэмдэглээд цааш нь *“эгшиг авиа нь өмөнөх төвөнхийн гийгүүлэгчтэйгээ нийлж нэг урт эгшиг үүссэн гэж үзэж болмоор байна”* гэжээ.¹³ Зохиогч энэ санаагаа дэлгэрүүлэн тайлбарлаагүй боловч төвөнхийн гийгүүлэгчийн тухай асуудалыг хөндсөн нь анхаарал татаж байна. Тэрбээр монгол бичигийн хэлний хоёр эгшигийн хооронд байсан шүргэх γ/g гийгүүлэгч нь яваандаа суларч, нэгэн үе төвөнхийн сул шүргэх **h** болсоныг монгол дөрвөлжин бичигийн дурасхалаас олж ажиглаад, уламаар түүнийг урт эгшигийн гаралтай холбож үзсэн бололтой.

Түүний дараа G. J. Ramstedt *“Бичигийн хэлэнд хоёр эгшигийн дунд олонтаа тохиолддог γ/g-гийн хоёр талын эгшигүүд хоорондоо нийлж, нэгэн урт эгшиг болсон байна”*¹⁴ гэжээ. Урид нь А. Бобровников хоёр богино эгшигийн нийлбэрээс урт эгшиг үүссэн байх боломжийг үгүйсгэж байсан боловч тэрбээр монгол бичигийн хэлний CVC (Vγ/gV) гэсэн нийлцээс урт эгшиг үүссэн гэдэгт бат итгэж байжээ. Бас тэрбээр урт эгшигийн үүсэлтэй холбогдуулан *“Энд шүргэх γ, хамжих ḡ-гийн ялгаанаас гадна өргөлтийн ялгаа ч бас байсан байж магадгүй”*¹⁵ хэмээн цухас дурдсан нь дараагийн судалгаануудад хүчтэй нөлөөлсөн маш нарийн ажиглалт болсоныг онцлон тэмдэглэвэл зохино. G. J. Ramstedt-ийн дараа Б. Я. Владимирцов *“хоёр эгшигийн хоорондох шүргэх γ/g нь олонхи тохиолдолд гээгдэж, түүний хоёр талын эгшигүүд нь хоорондоо нийлж, нэгэн урт эгшиг болсон”*¹⁶ гэсэн бол N. Порре мөн дээрхи саналыг давтан *“хоёр эгшигийн хоорондох γ/g нь алгуурханаар сугарч, уламаар түүний өмөнө, хойнох эгшигүүд нь хоорондоо нийлж, нэгэн урт эгшиг болсон”*¹⁷ гэсэн бий. Эдгээр санал

¹² А. А. Бобровников, Грамматика монгольско-калмыцкого языка, Казань, 1849, 12

¹³ А. А. Бобровников, Грамматика монгольско-калмыцкого языка, Казань, 1849, 12

¹⁴ G. J. Ramstedt, Das schriftmongolische und die Urgamundart phonetisch verglichen, JSFOu 21, 1903, 23-25. // Рамстедт, Г. И. Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора, С-Петербург, 1908, 22-25

¹⁵ G. J. Ramstedt, Das schriftmongolische und die Urgamundart phonetisch verglichen, JSFOu 21, 1903, 24. // Г. И. Рамстедт, Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора, С-Петербург, 1908, 23

¹⁶ Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, Лгр., 1929, 193

¹⁷ N. Poppe, N. Introduction to Mongolian Comparative Studies {= MSFOu 110}, 1955, 60

нь цөм G. J. Ramstedt-ийн саналаас үүдэлтэй юм. Хожим Ш. Лувсанвандан VCV гэсэн нийлцийн арын “*өргөлтөт үеийн эгшигийн сунжирч хэлэгдэх нь хэвшин хэвшисээр тогтвортой урт эгшиг болж, үг, морфемын утга ялгах гол үүрэг нь өргөлтөөс урт эгшигт шилжиж, биеэ даасан урт эгшиг фонем үүссэн*” гэж үзсэн байна.¹⁸ Энэ санаа нь угтаа XX зууны эхээр G. J. Ramstedt урт эгшигийн үүсэлд өргөлтөт нөлөөлсөн байж магадгүй гэсэн санаа цухалзуулсаныг өлгөн авч, уламаар түүнийг ‘*утга ялгах өргөлтөт фонем*’ (suprasegmental phoneme)-той холбон онолжуулсан тайлбар юм. Тэрбээр энэ санаагаа улам цааш нь лавшируулж утга ялгах өргөлтөт эгшиг нь анхандаа фонемийн хувилбарын шинжтэй байсанаа цаашид улам сунжирсаар яваандаа бие даасан фонемийн үүрэгтэй болсон гэжээ.¹⁹

Монгол хэлний урт эгшиг нь хоёр богино эгшигийн нийлцээс ч үүсээгүй, өргөлтөт эгшигээс ч үүсээгүй, харин “*авиа салаалан хөгжих дивергенцийн хуулийн дагуу дан богино эгшигээс үүссэн*”²⁰ гэсэн өвөрмөц саналыг Ж. Санжаа гаргажээ. Энэхүү санал нь үүсмэл урт эгшигийн гаралыг өөр талаас эрж хайж олох гэсэн шинэлэг хандлага мөн боловч богино эгшигээс урт эгшиг үүсэн бүрэлдсэн авианы орчин, гадаад нөлөөлөл зэрэгийг түүхэн авиа зүйн үүднээс тайлбарласангүй. Өөрөөр хэлбэл, дурын богино эгшигээс урт эгшиг үүссэн үү, эсвэл ямар нэгэн тодорхой байранд байсан богино эгшигээс урт үүссэн үү, урт эгшигийн үүсэлд ямар авиа хэрхэн нөлөөлсөн бэ гэх мэт асуултад тодорхой хариулт өгсөнгүй.

Дээр дурдсан судалгаануудад дэвшүүлсэн үзэл санаа болон монгол хэлний авианы хувьсан хөгжих ерөнхий зүй тогтолын үүднээс авч үзвэл үүсмэл урт эгшиг нь барагцаалбал, эртний монгол хэлний сүүлч үеэс үүсэн бүрэлдсэн гэж үзэх нь бодит байдалд илүү ойртох буй заа.

4. Үүсмэл урт эгшиг авианы бүтэц, тогтолцоонд хэрхэн нөлөөлсөн бэ? Барагцаалбал, эртний монгол хэлний сүүлч үеэр үүсэн бүрэлдсэн урт эгшиг нь зэрэгэлдээх авиануудынхаа хэлэгдэх шинжид зохих хэмжээгээр нөлөөлжээ. Үүсмэл урт эгшигийн нөлөөнд хамагийн их өртөж, өөрчилөгдсөн авиа бол түүний өмөнөх шүргэх *ʏ/g* гийгүүлэгч юм. Монгол хэлний урт эгшигийн гаралын талаар сонирхон судалсан G. J. Ramstedt, Б. Я. Владимирцов, Г. Д. Санжеев, N. Poppe нар²¹ бичигийн хэлний хоёр эгшигийн дундах *ʏ/g* гийгүүлэгч сугарсан талаар удаа дараалан дурдсан боловч тэдгээр гийгүүлэгч авианы ямар нөлөөгөөр хэрхэн сугарсан тухай асуудалыг бараг хөндсөнгүй орхигдуулжээ. Өөрөөр хэлбэл, тэдгээр эрдэмтэд хоёр эгшигийн дундах *ʏ/g* гийгүүлэгчийн олон үе шаттай хувьсалын хамагийн эцэсийн үр дүн болох сугарал (dropping)-ыг олж

¹⁸ Ш. Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний урт эгшигийн гарлын тухай асуудалд, ХЗС 4:1, 1966, 22

¹⁹ Ш. Лувсанвандан, дурдсан зохиол, 21-22

²⁰ Ж. Санжаа, “*Монголын нууц товчоо*” хийгээд монгол бичгийн хэлний урт эгшигийн гарлын тухай шинэлэг санал, МУИС МСС. ЭШБ 16:8, 2000, 73

²¹ Г. И. Рамстедт, Сравнительная фонетика монгольского письменного языка, С-Петербург, 1908, 22; Б. Я. Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, 193; Г. Д. Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, М., 1953, 77-78; N. Poppe, Introduction to Mongolian Comparative Studies, Helsinki, 1955, 60

харсан боловч сугарахын өмөнөх хувьсалыг түүхэн авиа зүйн онолын үүднээс тайлбарласангүй.

Эртний монгол хэлний сүүлчээр үүсэн бүрэлдсэн урт эгшиг нь дундад үеийн монгол хэлний үед өмөнөх гийгүүлэгчээ суларан сугарахад нөлөөлж эхэлсэнийг тухайн үеийн бичигийн дурасхалуудаас тодорхой мэдэж болно. Эртний монгол хэлний үед хоёр эгшигийн хооронд тогтвортой хадгалагдаж байсан шүргэх *ɣ/g* гийгүүлэгч арынхаа урт эгшигийн нөлөөгөөр хэрхэн суларсан хийгээд авианы орчиноосоо шалтгаалан ямар ямар хувилбарууд бий болсон явцыг түүхэн авиа зүйн үүднээс дөхөмхөн тайлбарлахыг зорив.

Эртний монгол хэлний хоёр эгшигийн хооронд байсан хамжих *ɣ/g* (velar stop) гийгүүлэгч нь арынхаа эгшигийг урт болсоны дараа түүний нөлөөгөөр сул шүргэх (weak aspiration) шинжтэй болж, уламаар дундад үеийн монгол хэлний үед зэрэгэлдэх эгшигүүдийн нөлөөгөөр ерийн сул шүргэх *h*, уруулын шүргэх *ʍ*, тагнайн шүргэх *ɣ* болсоныг монгол дөрвөлжин, хитад ханз, араб үсэгээр тэмдэглэсэн монгол хэлний бичигийн дурасхалууд тодорхой тусхасан байна. Тийнхүү хоёр эгшигийн хооронд байсан *ɣ/g* гийгүүлэгч сугаран гээгдсэн үйл явц нь угтаа ‘сугарал’ (deletion / dropping) гэдэг хувьсал биш, харин ‘суларал’ (lenition / weakening) гэдэг хувьсалын эцэсийн үр дүн юм. Тийм учираас энэ тухай асуудалыг ‘авианы суларал’ хэмээх онолын үүднээс авч үзэх ёстой юм. Дэлхийн олон хэлэнд түгээмэл тохиолддог *авианы суларал* гэдэг нь үгүүлэх эрхтэнүүдийн булчингийн хүчдэл суларч, дууны сүвээр дамжин өнгөрөх хийн урасхал илүү чөлөөтэй болсоноор зэрэгэлдэх авианыхаа давамгайл нөлөөнд хилбархан автах байдалтай болж, уламаар үгүүлэгдэх үндэсэн шинжээ аажимаар алдаж, эцэстээ бүрмөсөн сугаран гээгдэхийг хэлдэг ажээ. Өөрөөр хэлбэл, нэг талаас ‘хүчдэлийн хэмжээ’ (strength scale), нөгөө талаас ‘дуурхаг шинжийн хэмжээ’ (sonority scale) хоёрын уялдаа хамааралаар тухайн гийгүүлэгчийн суларалыг баримжаалан тогтоодог байна.

Эртний монгол хэлний хоёр эгшигийн хоорондоос суларан сугарсан гийгүүлэгчийн талаар анх түрүүн ажиглан тэмдэглэсэн эрдэмтэн бол Ш. Лувсанвандан юм. Тэрбээр “Монгол хэлэнд урт эгшиг бий болсон явдал нь өмнөх *ɣ, g, b* мэтийн хамжих гийгүүлэгчийг алгуурхнаар шүргэх байдалтай болгож сулруулан фонемын үүрэг гүйцэтгэж байсан гийгүүлэгчийг дан ганц авиа салгах үүрэгтэй болгож” хэмээн товч, тодорхой дурдсан байна.²² Энэ нь арынхаа урт эгшигийн нөлөөгөөр өмөнөх гийгүүлэгч нь суларч, хамжихаас шүргэх, шүргэхээс авиа зааглах амисхалын сул түрэлт болж, фонемын үүрэгээ алдсан тухай товч, тодорхой үгүүлсэн хэрэг юм. Тийнхүү хоёр эгшигийн дунд байсан шүргэх *ɣ/g* гийгүүлэгч нь арынхаа урт эгшигийн нөлөөгөөр суларах явцдаа хэд хэдэн үе шатыг дамжиж, бас хэд хэдэн хувилбартай болжээ. Үүнд:

а. Хэрэв шүргэх *ɣ/g*-гийн арын эгшиг нь ерийн урт *ā, ē* байсан бол тэр нь суларахдаа төвөнхийн сул шүргэх *h* болж, уламаар цаашдаа үгүүлэхийн хувьд ч, сонсол зүйн хувьд ч үе зааглах амисгалын түрэлт болсон байна.

²² Ш. Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний урт эгшигийн гарлын тухай асуудалд, ХЗС 4:1, 1966, 22

AM *qayān* (Bod, Hin, Jig, Chan.) > MM *qahān* (MNT, HY) > *qa'ān* (MNT, DB, Ist.)
AM *gegegen* (Bur, Hin.) > **gegehēn* > *gege'ēn* (MNT, DB)

b. Хэрэв шүргэх *ɣ/g*-гийн арын эгшиг нь уруулын, урт *ū*, *ũ* байсан бол тэр нь суларахдаа уруулын шүргэх *w* болж, уламаар цаашдаа үе зааглах амисхалын түрэлт болсон байна.

AM *dayūn* (Bod, Chang, Taq.), MM *dawūn* (MNT, HY) > *da'ūn* (Mu.)
AM *jegūn* (Hin, Qqot, Bur.), MM *jewūn* (MNT, L.) > *je'ūn* (Hy, Mu.)

с. Хэрэв шүргэх *ɣ/g*-гийн арын эгшиг нь тагнайн урт *ī* байсан бол тэр нь цаашид суларахдаа тагнайн шүргэх *y* болж, уламаар цаашдаа үе зааглах амисхалын түрэлт болсон байна.

AM *sayīn* [< *sayīn] (= Bod, Aruγ, Ölj.), MM *sayīn* (MNT, DB, Mu, IM) > *saīn* (Mu, IM.)
AM *teyīmū* [< *tegīmū] (= Taq, Bur.), MM *teyīmū* (MNT) > *te'īmū* > *ti'īmū* > *tīm* (Mu.)
AM *oyīra* [< *oyīra] (= Ölj, Hin, Chang.), MM *oyīra* (MNT, HY, Mu, IM.) > *oīra* (Mu, Ist.)
AM *ugīla-* (Bur.) > *uyīla-* (Taq.), MM *uyīla-* (MNT) > *u'īla-* > *uīla-* (Mu, IM, L.)

Монгол хэлэнд үүсэн бүрэлдсэн урт эгшигийн нөлөөгөөр хувьсалд орсон өөр нэг авиа бол суларсан гийгүүлэгчийн өмөнө байсан богино эгшигүүд юм. Энэ талаар Ш. Лувсанвандан: “урт эгшигийн биеэ даасан байдал улам бэхжихийн хэрээр мөн гийгүүлэгчийн өмнөх богино эгшиг улам огцом болж, ... үг морфемын утга ялгах бие даасан фонемынхоо үүргийг түргэн алдаж ... сугаран гээгдсэн гийгүүлэгчийн хоёр этгээдэд байсан богино, урт хоёр эгшиг шууд залгах болсон байна”²³ хэмээн тэмдэглэсэн нь сугарсан гийгүүлэгчийн өмөнөх богино эгшигийн цаашдын хувьсалыг бодьтойгоор тодорхойлсон хэрэг юм.

Дээр дурдсан богино эгшигийн хувьсалын талаар бага зэрэг тодруулан хэлбэл: уруулын бус урт эгшигийн өмөнөх үеийн богино эгшиг нь фонемын үүрэгээ аажимаар алдаж, арын урт эгшигтээ уусан шингэсэн бол уруулын урт эгшигийн өмөнөх үеийн богино эгшиг нь арынхаа урт эгшигт татагдан ижилшиж, уруулын эгшиг болсоныхоо дараа аажимаар дараах урт эгшигтээ уусан шингэжээ.

AM *qayān* (Bod, Chang.) > MM *qahān* (MNT, KMQB.) > *qa'ān* (MNT, DB)
AM *kegēli* (Bur.) > MM *kehēli* (IM.) > *ke'ēli* (MNT, HY)
AM *dayūn* (Bod, Bur.) > MM *dawūn* (MNT, Hy.) > *da'ūn* (MNT, Mu.) > **do'ū* > *du'ū* (Mu.)
AM *jegūn* (Hin, Bur.) > MM *jewūn* (MNT) > *je'ūn* (Hy, Tk, Mu.) > *jö'ūn* (HY.) > *jü'ūn* (Mu.)

Дээр дурдсанчилан хоёр эгшигийн хооронд байсан хамжих *ɣ/g* гийгүүлэгч нь арынхаа үүсмэл урт эгшигийн нөлөөгөөр суларан шүргэх болж, уламаар шүргэхээс сул шүргэх, сул шүргэхээс авиа зааглах амисхалын түрэлт болсон нь түүний олон шат дамжсан суларалын хамагийн сүүлчийн шат юм.

Эцэст нь тэмдэглэхэд: эртний монгол хэлний хоёр эгшигийн хооронд байсан шүргэх *ɣ/g* гийгүүлэгч сугарсан учираас урт эгшиг үүссэн бус, харин урт эгшиг үүссэн учираас түүний нөлөөгөөр өмөнөх гийгүүлэгч нь суларан сугарчээ.

²³ Ш. Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний урт эгшигийн гарлын тухай асуудалд, ХЗС 4:1, 1966, 22, 24

5. Урт эгшигийг бичигт хэрхэн тэмдэглэж байсан бэ? Монгол бичигийн хэл анх үүсэн бүрэлдэж, хэвшин тогтсон тэр цагт урт хараахан үүсээгүй байсан тул түүнийг тусхай үсэгээр ялган тэмдэглэсэнгүй. Энэ талаар Ш. Лувсанвандан: “Хуучин монгол бичгийн хэлний зөв бичих дүрэмд өргөлт буюу эгшигийн уртыг заасан ямар ч тэмдэг байхгүй байгаагаас үзэхэд анх уйгуржсин монгол үсгийг зохион хэрэглэх тэр үед биеэ даасан урт эгшиг фонем байгаагүй”²⁴ хэмээн тэмдэглэсэн бий.

Тийнхүү монгол бичигт урт эгшигийг тусхайлан тэмдэглээгүй боловч урт эгшиг үүсэн бүрэлдсэн авианы орчиноор нь баримжаалан түүнийг хилбархан тогтоох боломжтой. Гэтэл зарим судлаачид энэхүү байрлалын боломжийг эгшигийн уртыг заасан зориудын тэмдэг мэтээр ойлгосон нь цөөнгүй. Одоогоос 170 гаруй жилийн өмөнө А. Бобровников монгол бичигийн хэлний VCV гэсэн бүтэцтэй холбогдсон нэгэн сонирхолтой санал дэвшүүлжээ. Тэрбээр бичигийн хэлний *aya, ege, ayu, egü* гэсэн бүтэц нь уулаасаа байсан уу, эсвэл одоогийн амид хэл аялгууны урт эгшигийг монгол бичигт *aya, ege, ayu, egü*-гээр тэмдэглэсэн үү гэдэг асуулт тавиад “энэ асуултад оновчтой хариулт өгөхөд амаргүй. Миний хувийн бодолоор бол сүүлчийнх нь илүү үнэмшилтэй”²⁵ гэжээ. Энэ нь угтаа VCV гэсэн цогцын доторхи *γ/g*-гийгүүлэгч нь урт эгшигийг заасан тэмдэг байж магадгүй гэсэн санаа юм. Хожим Ж. Санжаа дээрхи саналыг өлгөн авч, монгол бичигийн урт эгшигийн өмөнөх *γ/g* нь уулаасаа байгаагүй, урт эгшигийн байрыг заахын тул хожим нэмэн бичих болсон гэсэн санааг дэвшүүлж, түүнийгээ “монгол бичгийн хэлэнд хоёр эгшиг нэг доор үл байрлах жамтай тул богино, урт эгшигийн заагт *γ, g* зэрэг гийгүүлэгчийг нэмэн жийрэглэж бичдэг болжээ”²⁶ гээд цааш нь “монгол бичгийн хэлний уртатгал нь эртний монгол хэл аялгууны аман дуудлагын тусгал биш, монгол бичгийн хэлний зохиомол хэлбэр юм”²⁷ гэжээ. Гэвч ингэж үзэх нь сонирхолтой санал мэт боловч үсэг зүйн хувьд зарим нэгэн эргэлзээтэй асуудалтай тулгарч байна. Юуны өмөнө “жийрэгийн” *γ, g* үсэгийг урт, богино хоёр эгшигийн хооронд нэмэж бичихээс өмөнө “хоёр эгшиг нэг доор үл байрлах жамтай” монгол бичигт тэр хоёр эгшигийг хэрхэн залган бичиж байсан бэ гэсэн асуулт гарч ирнэ. Энэ асуултад монгол бичигийн үсэг зүйн тогтолцооны үүднээс ойлгомжтой хариулт олохгүй бол “жийрэгийн” *γ, g*-ийн тухай таамаг батлагдахгүйд хүрнэ.

Монгол бичигээс гадана дундад үеийн монгол хэлний нийтлэг шинжийг тусхасан дөрвөлжин бичигт урт эгшигийг хэрхэн тэмдэглэсэн тухай асуудал ч бас эрдэмтэдийн анхааралыг татсаар иржээ. Энэ талаар хамагийн анх А. Бобровников “дөрвөлжин үсэгийн дурасхалуудад урт эгшигтэй үгийг үеэр зааглахдаа хооронд нь □ (*q*) бус, харин ▢ (*a*)-г бичсэн нь эгшигийн уртыг заасан бололтой”²⁸ хэмээн тамаглажээ. Түүний гаргасан энэхүү таамаг нь хожимоо нотолгоо мэт ойлгогдох

²⁴ Ш. Лувсанвандан, Дурдсан зохиол, 21-22

²⁵ Бобровников, А. А. Грамматика монгольско-калмыцкого языка, Казань, 1849, 16

²⁶ Ж. Санжаа, “Монголын нууц товчоо” хийгээд монгол бичгийн хэлний урт эгшигийн гарлын тухай шинэлэг санал, МУИС МСС. ЭШБ 16:8, 2000, 73

²⁷ Ж. Санжаа, дурдсан үгүүлэл, 73

²⁸ А. А. Бобровников, Грамматика монгольско-калмыцкого языка, Казань, 1849, 17

болжээ. Тухайлбал: XX зууны эхээр G. Clauson, S. Yoshitake нар төвөд бичиг болон монгол дөрвөлжин үсгийг харьцуулан үзсэн судалгаандаа дөрвөлжин үсгийн **ᠯ** (*a*)-гаар эгшигийн уртыг тэмдэглэнэ²⁹ хэмээн дурдсан бол G. Clauson хожим бичсэн “Дөрвөлжин үсэг” гэсэн тусхай үгүүлэлдээ мөн өмөнөх санаагаа давтан ‘**ᠯ** (шанаган *a*) нь эгшигийн уртыг заана’³⁰ гэжээ. Бүр хойно Ш. Лувсанвандан дөрвөлжин бичигийн дурасхалд гийгүүлэгчийн дараа шууд залган орсон *шанган a*-г уртын тэмдэг гэж дурдаад уламаар хоёр эгшигийн хоорон орсон *шанаган a*-гийн талаар: “дөрвөлжин үсгийн *шанаган a* нь хэзээ ч хоёр эгшигийн зааглагч байгаагүй, харин үеийн эцэст тохиолдвол өмнөх үе үсгийнхээ эгшигийн уртыг заасан тэмдэг болдог”³¹ гэсэн нь угтаа монгол бичигийн хэлний хоёр эгшигийн дундах *γ/g*-гээр баримжаалан урт эгшигийн байрлалыг тогтоож болдогтой адил дөрвөлжин бичигийн *шанаган a*-гаар баримжаалан арынх нь урт эгшигийг олж болно гэсэн санааг илэрхийлжээ. Ер дөрвөлжин бичигийн *шанаган a* нь анхнаасаа хоёр эгшигийн хоорондох шүргэх гийгүүлэгчийг тэмдэглэхэд зориулагдсан үсэг. Харин түүний авиа зааглах болон эгшигийн уртыг заах шинж нь уулаасаа түүнд оногдсон үүрэг биш, зөвхөн түүний байрлалын онцлог юм. Тийм ч учираас Ш. Лувсанвандан “*шанаган a* нь хэзээ ч хоёр эгшигийн зааглагч байгаагүй” гэж тусхайлан дурдсан биз ээ. Хэрэв *шанаган a*-г уртын тэмдэг гэж үзвэл монгол бичигийн *γ/g* ч бас уртын тэмдэг болно. Түүнчилэн хитад ханз үсэгээр тэмдэглэсэн “Монголын нууц товчоо” болон Мин уласын үеийн хитад-монгол толь бичигүүдэд хоёр эгшигийн дундах шүргэх гийгүүлэгчийг 阿, 額, 兀 зэрэг үсэгээр тэмдэглэсэн байна.

Монгол хэл шинжилэлийн бүтээлүүдэд урт эгшиг үүсэн бүрэлдсэн авианы орчиныг их төлөв VCV гэсэн бүтэцээр төлөөлүүлэн үзэхдээ түүнийг *group*, *комплекс*, *сочетание*, *цогц*, *нийлц* гэх мэт өөр өөрөөр томьёолсоор иржээ. Бас зарим эрдэмтэд түүнийг *ууа* (*üge*)-гээр төлөөлүүлэн үзсэн нь ч бас бий.³² Харин сүүлийн үед Өвөр Монголын эрдэмтэд VCV гэсэн бүтэцийг бүхэлд нь “уртадхал”³³ хэмээн нэрийдэх болжээ.

Эцэст нь ‘уртадхал’ гэсэн энэ нэр томьёогоор чухам юуг илэрхийлэх вэ гэдэг асуудалын талаар саналаа хуваалцаж. Монгол бичигийн дурасхалууд болон монгол бичигийн хэлэнд хэвшин тогтсон зарим үгийн бүтэцийг задалж үзвэл бүтээвэрийн үүрэггүй, зөвхөн өмөнөх үеийнхээ эгшигийн уртыг заасан мэт *γa/ge* гэсэн нэмэлт үе хааяа тохиолдож байна. Жишээлбэл: уйгуржин бичигийн

²⁹ G. Clauson, S. Yoshitake, On the Phonetic Value of the Tibetan Characters ‘*l*’ and ‘*h*’ and the Equivalent Characters in the Phags-pa Alphabet, JRAS 61:4, 1929, 843-862

³⁰ G. Clauson, The hP’ags-pa Alphabet, BSOAS 22, 1959, 319

³¹ Ш. Лувсанвандан дөрвөлжин үсгийн дурсгалын зүйлд эгшигийн урт, богиныг ялгасан нь, ХЗС 4:2, 1966, 33

³² N. Poppe, The Groups **uua* and **üge* in Mongol Languages, StO 14:8, 1950, 3-15; K. Thomsen, Entwicklung der Gruppe **uua* (**üge*) im Mongolischen, AOH 23, 1958, 263-267; H. Kuribayashi, The Development of **uua* and **üge* in Mongolian, JLSJ 85, 1985, 22-48

³³ Цагаансар, Uiyurjin mongyol bičig-tü ileregsen urtu egesig-lüge qolbuydaysan bičilge-yin tuqai, ÖMYS 4, 2002, 42-48; Жин Ган, Mongyol kelen-ü urtudqal бүтүңе-yin emüneki egesig-ün sudulul, Kökeqota-yin ündüsüten-ü degedü surγayuli. ESB 3, 2011, 16-22; Mongyol kelen-ü urtudqal бүтүңе-yin qoyinaki egesig-ün sudulul, ÖMYS 3, 2011, 47-58; Дуран, Mongyol bičig-ün kelen-ü urtudqal бүтүңе VCV-yin Dünsiyang kelen-dü ki kögöl qubiral-un tuqai, ÖMYS 1, 2016, 26-30

эртний дурасхалуудад тохиолддог *čaɣaɣan*, *gegegen* гэсэн үгсийг бүтэцээр нь задалбал **ča-* {= *ča*-ki, *ča*-l, *ča*-yi}, **ge-* {= *ge*-re, *ge*-yi} гэсэн анхдагч язгуур болон үг бүтээх *-ɣan*, *-gen* дагавараас бүтсэн нь тодорхой харагдаж байна. Гэтэл тэдгээрийн хооронд байгаа *-ɣa*, *-ge* гэсэн үе нь үг бүтээх үүрэггүй, зөвхөн арынхаа эгшигийн уртыг заах үүрэггүй байгаа мэт ажиглагдаж байна. Түүнчилэн эртний бичигийн дурасхалууд болон монгол бичигийн хэлэнд байгаа *ɣadaɣa-du*, *dotuɣadu*, *ilege-*, *ibege-*, *jögege-*, *tegege-*, *umdayan* гэх мэт үгэсийн бүтэцэнд байгаа *-ɣa*, *-ge* гэсэн үе нь *ɣada*, *dotu*, *ibe-*, *ile-*, *jöge-*, *tege-*, *umda* гэх мэт өмөнөх язгуурынхаа бүтэцэн дэх эгшигийн уртыг заасан байж ч магадгүй байна. Учир нь гэвэл: сонгодог бичигийн өмөнөх монгол бичигийн дурсхалуудад тохиолдож байгаа *ɣada* (гадаа), *ibe-* (ивээ-), *ile-* (илээ-), *jöge-* (зөө-), *tege-* (тээ-), *umda* (ундаа) гэх мэт үгс нь тухайн үедээ урт эгшигтэй хэлэгдэж байсан бололтой. Хэрэв тийм бол монгол бичигийн хэлний VCV гэсэн бүтэцийг бус, харин өмөнөх болон арын эгшигийнхээ уртыг ялган заах үүрэгтэй *-ɣa*, *-ge* гэсэн нэмэлт үеийг л ‘*уртадхал*’ гэж нэрлэх нэрлэвэл илүү оновчтой мэт. *Уртадхал* гэсэн нэршилтэй холбогдуулан гаргаж буй энэхүү санаа нь хэлний баримтаар бүрэн батлагдаагүй, зөвхөн цаашид нихталан судлах сэдэл төдий санал юм.

Бичигийн хэл нь дагаж мөрдөх хэвшин тогтсон дүрэм зүйтэй ч гэсэн хэрэглэгчидийн дөхөмчилөх сэдхэлгээний нөлөөгөөр амид хэл ярианыхаа бодит дуудлагыг бичигтээ тусгах гэсэн өрөөсхөл хандлага ямагт байсаар иржээ. Бидний хамагийн сайн мэдэх ойрын жишээ бол XX зууны үеэс эхлэн монгол бичигийнхээ тогтсон дүрэмийг гажуудуулан *-mui/-müi*, *luɣ-a/-lüge*, *-juqui/-jüki* мэт дагаваруудыг *n-a/-n-e*, *l-a/-l-e*, *jai/-jei* гэх мэтээр хилбарчилан бичих болсон билээ. Монгол бичигийн хэлэнд энэ мэт уламжилалт бичлэгээсээ гажсан язгуур, үндэс, дагавар, нөхцөлүүд цөөнгүй бий билээ. Бичигийн хэлээ ярианы хэлэндээ дөхүүлэх гэсэн тийм хандлага бүр XIII-XIV зууны үеийн монгол бичигийн хэлэнд ч бас гарч байсан байхыг үгүйсхэх аргагүй.

Монгол хэлний урт эгшигийн үүсэл болон түүний эргэн тойронд болсон авианы хувьсалын тухай миний эргэцүүлэл энэ буюу.

Abstract

The derivation of long vowels represents one of the major developments in the historical phonology of Mongolian. The origin and development of long vowels have been studied for nearly two centuries, yet many issues remain contested. These include the precise time of their formation, the phonetic environments in which they arose, possible external influences, and how these were reflected in the written language. Another debated issue is the influence of derivational long vowels on neighboring sounds. In this paper, we discuss all of these disputed problems.

Key words: Phonetic causes of long vowel derivation. Influence of derivative long vowels on neighboring sounds. Representation of derivative long vowels in the Uighur-Mongolian and ‘Phags-pa scripts